

**ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ НАСТНУУДЫН  
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНД ДЭВШҮҮЛСЭН САНАЛЫН ДАГУУ  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**2019 оны 12 дугаар сарын 19**

| №  | Дэвшүүлсэн санал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Гүйцэтгэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | <p>-Хэвтэх эмнэлэгтэй болмоор байна.</p> <p>-Байраа сайжруулах хэвтэн эмчилдэг болмоор байна.</p> <p>-Эндээ шинжилгээ авдаг, хэвтэн эмчлүүлдэг болмоор байна.</p> <p>-1 өрөөнд 2 эмч сууж ажиллаж байгаа нь өвчтөнтэйгээ харьцахад хүндрэлтэй байна. Энд дандаа өндөр настнууд (хараа муу, дүлий гэх мэт) үйлчлүүлдэг учраас эмнэлгийн байрыг томруулж өгөх шаардлагатай байна.</p> | <p>-Хэвтэн эмчлүүлэх эмнэлэг 2020 оны 6 сард ашиглалтанд орохоор яригдаж байна. Ажлын байрны хүрэлцээ муу учраас шинжилгээ авах, хэвтүүлэн эмчлэх боломжгүй байна.</p> <p>-Эмнэлгийн дотор тохижилтийг сайжруулахын тулд 2019 онд коридор, эмчилгээний өрөөнүүдэд засвар хийсэн.</p> <p>-Мөн явган хүний зам шинээр хийж, гадна нүүрэнд бүрэн засвар хийсэн.</p> |
| 2. | <p>-Эхоны эмчийг байнга ажиллуулах шаардлагатай байна, амарсан үед нь түр эмч ажиллуулж өгнө үү.</p> <p>-Миний хувьд эхоны эмч 2 байвал хурдан шуурхай үзвэл ачаалал арай бага болох юм шиг санагдлаа.</p>                                                                                                                                                                          | <p>-Эхоны эмчийн оронд түр эмч авч ажиллуулж байгаад эхоны байнгын орон тооны эмч авсан.</p> <p>-Өрөө тасалгаа болон орон тоо хүрэлцэхгүй байгаа тул боломжгүй.</p>                                                                                                                                                                                              |
| 3. | Ясны сийрэгжилт үздэг болмоор байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Ясны сийрэгжилтийн аппаратыг олон жил ашигласан бөгөөд эвдэрсэн байгаа тул тоног төхөөрөмжийн засварчинд үзүүлж засуулахаар болсон.                                                                                                                                                                                                                              |
| 4  | Бөөрний эмч, гэмтэл, мэс заслын эмчтэй болох                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Дотрын эмч ажиллаж байна. Гэмтэл, мэс заслын эмчийг одоогийн батлагдсан орон тооны хүрээнд ажиллуулах боломж бололцоо байхгүй.                                                                                                                                                                                                                                   |
| 5  | Уламжлалт анагаах ухааны эмчилгээний өрөөг томсгох талаар анхаарвал сайн байна.                                                                                                                                                                                                                                                                                                     | Өрөө тасалгааны хувьд шинэ эмнэлэг ашиглалтанд ортол томсгох боломжгүй байна. Одоогоор нийт 17 өрөөнд үйл ажиллагаа явуулж байна.                                                                                                                                                                                                                                |
| 6  | Гадна талбай болон дотор цэвэрлэгээ дунд зэрэг байна.                                                                                                                                                                                                                                                                                                                               | Гадна талбайд шинээр явган хүний зам болон хашлага шинээр хийсэн, цэвэрлэгээг өдөр бүр хийж байна. Дотор цэвэрлэгээг сайжруулах тал                                                                                                                                                                                                                              |

|    |                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                                                                                                                      | дээр хяналт хийж, шаардлага тавьж ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| 7  | Ахмадын дасгал хөдөлгөөний кабинет хаана байдаг вэ?<br>Хэд дэх өдөр, хаана хэдэн цагаас явагддаг вэ?                 | Шинээр эмнэлэг баригдвал хэрэгжинэ. Албан байгууллагын хүсэлтийн дагуу дасгалын сургалтыг хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотод хийж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| 8  | Коридорын суух сандал хүрэлцэхгүй, үүдээр зогсож үйлчлүүлсэнд жаахан хүндрэлтэй байлаа.                              | Корридорт шинээр 7 сандал тавьсан, 1 хуучин сандал байгаа, өөр сандал багтах зай талбай хүрэлцэхгүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 9  | Зүрхний эхо хийдэг, цусны шинжилгээ авдаг болмоор байна.                                                             | Долоо хоногийн Мягмар, Пүрэв гаригт үдээс хойш зүрхний эхо хийлгэх шаардлагатай үйлчлүүлэгчид хийж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 10 | Ходоодны дурантай болгох.                                                                                            | 2019 онд Сөүл-сонгдо эмнэлэгтэй хамтран ажиллаж ходоодны дурангийн шинжилгээнд үйлчлүүлэгчдийг хамруулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 11 | Сэргээн засах эмчилгээг олон хоног болгомоор байна.                                                                  | Сэргээн засах эмчилгээний эмчийн зааврын дагуу хийгддэг. Тухайн үйлчлүүлэгчийн эмчлүүлэх шаардлагатай хугацаагаар эмчилгээ хийгддэг.                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| 12 | Үйлчилгээ боломжийн сайн байгаа. Иргэдийн ухамсар хувийн харьцаа тааруу учир иргэдэд зөвөлгөө өгч баймаар санагдлаа. | “Инээмсэглэл эерэг хандлага”, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” уриан дор төвөөр үйлчлүүлж буй настануудад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Настанд туслая” аянг зохион байгуулан ажиллаж байна. Тус аяны хүрээнд төвийн ажилтнууд хуваарийн дагуу амбулаторийн тусламж үйлчилгээний ачаалал ихтэй үед настанд хөтөч, туслан зөвлөх үйлчилгээг үзүүлж байна. |

Тайлан хянасан:.....М.Адьяасүрэн /Хяналт үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн/

Тайлан бичсэн: .....А.Нэргүй /Лавлагаа мэдээллийн ажилтан/